



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн улсын төсвийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/1/НА-СТА-ЗГТС

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022 Ол. 17 № 2/22

танай _____-ны № _____-т
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн улсын төсвийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн улсын төсвийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

• 0050?0?37

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт		төгрөгөөр	
			Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
.	МӨНГӨ БА ТҮҮНГЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ [2]+[3]	1	1,326,607.00	-
3102	Банкинд байгаа бэлэн мөнгө/төгрөг/ [4]+[5]	3	1,326,607.00	-
310201	Банкинд байгаа бэлэн мөнгө/Улсын төсөв/	4	1,326,607.00	-
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН [1]+[6]	13	1,326,607.00	-
.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН [13]+[14]	15	1,326,607.00	-
510301	Өмнөх үеийн үр дүн	30		1,326,607.00
510302	Тайлант үеийн үр дүн	32	1,326,607.00	(1,326,607.00)
0	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН [30]+[31]+[32]+[33]	34	1,326,607.00	-
0	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН [29]+[34]	35	1,326,607.00	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөр	Үзүүлэлт		төгрөгөөр	
			ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТ ЫН ОРЛОГО [2]+[3]	1	14,121,312,000.00	5,919,704,800.00
130301	Улсын төсвийн санхүүжилтын орлого	2	14,121,312,000.00	5,919,704,800.00
14	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]	4	22,759,991.04	6,042,182.44
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	5	7,466,491.04	57,882.44
1401012	Улсын төсвийн бусад орлого	6	15,293,500.00	5,984,300.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]	9	14,144,071,991.04	5,925,746,982.44
2603	Төсөвт төвлөрүүлэх [16]+[17]	15	168,928,687.04	100,680,960.44
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	16	168,928,687.04	100,680,960.44
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [39]-р мөр	18	13,967,973,697.00	5,824,722,779.00
2701010101	Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт	21	5,968,955,600.00	1,461,650,439.00
2701010102	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	22	1,846,145,780.00	1,620,417,250.00
2701010103	Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	23	1,162,373,630.00	1,076,313,300.00
2701011000	Ихэр хүүхдийн тэтгэмж	24	40,000,000.00	-
2701010900	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	25	609,208,977.00	295,452,590.00
2701010105	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	27	220,696,650.00	173,858,550.00
2701010104	Жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	30	39,200,000.00	-
2701010106	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	32	1,931,451,750.00	1,166,853,650.00
2702010101	Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт	34	988,300,100.00	-
27020102	Ахмад дайчид алдар цолгон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	35	54,939,000.00	564,000.00
2702010400	Насны хишиг	36	598,480,000.00	
2701010700	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	37	235,949,520.00	
2701010800	Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн зардал	38	237,897,940.00	
2701010108	Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	41	34,374,750.00	29,613,000.00
.	Банкны шимтгэл [41]+[45]	43	5,843,000.00	1,669,850.00
.	Банкны шимтгэл УТ [42]+[43]+[44]..+[56]	44	5,843,000.00	1,669,850.00
2702010311	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл	55	5,843,000.00	1,669,850.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[40]	62	14,142,745,384.04	5,927,073,589.44
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН [9]-[50]	63	1,326,607.00	(1,326,607.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр				
Д/д	Үзүүлэлт		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3]	1	14,121,312,000.00	5,919,704,800.00
130301	Улсын төсвийн санхүүжилтын орлого	2	14,121,312,000.00	5,919,704,800.00
1401	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]+[9]+[10]	4	39,346,121.04	23,812,673.44
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	5	7,466,491.04	57,882.44
1401012	Улсын төсвийн бусад орлого	6	15,293,500.00	5,984,300.00
1401013	Улсын төсвийн буцаасан орлого	9	16,586,130.00	17,770,491.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ [1]+[4]	11	14,160,658,121.04	5,943,517,473.44
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [18]+...+[38]	17	13,984,559,827.00	5,842,493,270.00
2701021100	Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт	20	5,971,443,300.00	1,462,391,010.00
2701021200	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	21	1,848,892,210.00	1,623,508,820.00
2701010103	Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	22	1,164,433,630.00	1,076,493,300.00
2701021500	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	24	609,348,977.00	295,592,590.00
2701021604	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	26	220,696,650.00	173,858,550.00
2701022000	Жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	29	39,200,000.00	-
2701021300	Ихэр хүүхдийн тэтгэмж	24	40,000,000.00	-
2701024000	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	31	1,940,603,750.00	1,180,472,000.00
2702010101	Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт	33	988,300,100.00	-
27020102	Ахмад дайчид алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	34	54,939,000.00	564,000.00
2702010400	Насны хишгийн зардал	35	598,480,000.00	-
2701010700	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	36	235,949,520.00	-
2701010800	Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн зардал	37	237,897,940.00	-
2702020308	Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	40	34,374,750.00	29,613,000.00
.	Банкны шимтгэл [40]+[44]	42	5,843,000.00	1,669,850.00
.	Банкны шимтгэл УТ [41]+[42]+[43]	43	5,843,000.00	1,669,850.00
2702010311	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл	54	5,843,000.00	1,669,850.00
2603	Төсөвт төвлөрүүлэх [53]+[55]	64	168,928,687.04	100,680,960.44
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	65	168,928,687.04	100,680,960.44
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН [12]+[17]+[39]+[49]+[52]+[61]-[62]+[63]-[64]	67	14,159,331,514.04	5,944,844,080.44
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [11]-[56]	68	1,326,607.00	(1,326,607.00)
.	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [60]-[59]	69	1,326,607.00	(1,326,607.00)
.	Мөнгө, түүнтэй өдилгэх хөрөнгийн эхний үлдэгдэл	70	-	1,326,607.00
.	Мөнгө, түүнтэй өдилгэх хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71	1,326,607.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр					
Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01 сарын 1-ээрх үлдэгдэл	0	0	-	-
7	Тайлант үеийн үр дүн	0	0	1,326,607.00	1,326,607.00
8	2020 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	1,326,607.00	1,326,607.00
14	Тайлант үеийн үр дүн	0	0	(1,326,607.00)	(1,326,607.00)
15	2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр					
	Сангийн орлого	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	1,326,607.00	-	0.0
2	Сангийн үйл ажиллагааны зардал [3]+[4]+[5]+[6]+[7]+[8]+[9]+[10]+[11]+[12]	5,919,704,800.00	5,826,392,629.00	93,876,171.00	98.4
3	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тэтгэмж тусламж, хөнгөлөлт		564,000.00		
4	Банкны шитмгэл	3,600,000.00	1,669,850.00	1,930,150.00	46.4
5	Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	29,613,000.00	29,613,000.00	-	100.0
6	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал	319,534,000.00	295,452,590.00	24,081,410.00	92.5
7	Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт	1,476,000,000.00	1,461,650,439.00	14,349,561.00	99.0
8	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	1,620,000,000.00	1,620,417,250.00	(417,250.00)	100.0
9	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	1,090,000,000.00	1,076,313,300.00	13,686,700.00	98.7
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	203,517,800.00	173,858,550.00	29,659,250.00	85.4
11	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	1,177,440,000.00	1,166,853,650.00	10,586,350.00	99.1
12	УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	5,919,704,800.00	5,819,490,190.11		0.0
13	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0		-	0.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн улсын төсвийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн улсын төсвийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Улсын төсвийн халамжийн сангийн санхүүгийн тайланг Finance.hudulmur-halamj.gov.mn цахим программаар бэлтгэж Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газарт нэгтгүүлж байна.

Тайлант хугацаанд сангийн хөрөнгийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Д.Амарсанаа, 2 дугаар гарын үсгийг 2021.01.01-2021.08.31 хүртэл хугацаанд халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Долгорсүрэн, 2021.09.01-2021.12.31-ийг хүртэл Захиргаа хяналтын хэлтсийн дарга Д.Одонтунгалаг нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн улсын төсвийн Халамжийн сангийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн сангийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг бодитой, үнэн зөв боловсруулах, холбогдох газруудад хүргүүлэн батлуулах.
- Батлагдсан төсвийн зарцуулалтыг улирал, хагас бүтэн жилээр иргэдэд болон хэлтсийн удирдлага хамт олонд нээлттэй тайлагнаж ажиллах
- Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангах чиглэлээр санал санаачилга гарган, анхан шатанд ажиллаж байгаа ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах
- Нийгмийн халамжийн сангийн санхүүжилтийг цаг хугацаанд нь авах, бодитой, үнэн зөв хуваарилах, гэрээт банк уруу шилжүүлэх ажлыг чанартай зохион байгуулах
- Хуульд заасан тусламж хөнгөлөлтийн мөнгийг нэхэмжлэлийн дагуу холбогдох байгууллагад шилжүүлэх.
- Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлын баримт материалыг журмын дагуу бүрдүүлэн хүлээн авч, санхүүжилтийг журмын дагуу олгох. Амьжиргаа дэмжих зөвлөлийн ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөмж чиглэл өгөх, сургалт зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн улсын төсвийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн улсын төсвийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 14,142,745.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 141,427.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 98,999.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн улсын төсвийн Халамжийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,326.6 мянган төгрөгөөр буюу 100.0 хувь буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, Засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,326.6	-	(1,326.6)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	1,326.6	-	(1,326.6)
Авлага	-	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-	-
Нийт хөрөнгө	1,326.6	-	(1,326.6)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,326.6	-	(1,326.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,326.6	-	(1,326.6)

Өмнөх онд сангийн арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл 1,326.6 мянган төгрөгийг тайлант онд улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 16,645,871.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 16,645,871.2 мянган төгрөгөөр буюу нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт үйлчилгээнд 16,566,057.5 мянга, амьжиргаа дэмжих зөвлөл, хорооны гишүүдийн урамшуулал, үйл ажиллагааны зардалд 48,000.0 мянга, банкны шимтгэл хураамжийн зардалд 31,813.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс тайлант онд ихэр хүүхэд, жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж, алдарт эхийн одон, насны хишиг, цалинтай ээж, өрх толгойлсон эцэг, эх хөтөлбөрийн зардлыг цахим системээр улсын төсвөөс шууд санхүүжүүлэхээр болсонтой холбоотой 5,588,281.3 мянган төгрөгөөр бууруулж 10,977,776.2 мянган төгрөгөөр буюу нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт үйлчилгээнд 10,940,225.2 мянга, амьжиргаа дэмжих зөвлөл, хорооны гишүүдийн урамшуулал, үйл ажиллагааны зардалд 23,151.0 мянга, банкны шимтгэл хураамжийн зардалд 14,400.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 10,977,776.2 мянган төгрөгийн төсөв баталж, 1 удаа тодотгож улсын төсвөөс 5,919,704.8 мянга төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,919,704.8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, банкны хүүгийн орлогоор 57.9 мянга, бусад орлогоор 5,984.3 мянга, урьд оны дансны үлдэгдлээс 1326.6 мянган нийт 5,927,073.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт үйлчилгээнд 5,795,109.8 мянга, амьжиргаа дэмжих зөвлөл, хорооны гишүүдийн урамшуулал, үйл ажиллагааны зардалд 29,613.0 мянга, банкны шимтгэл хураамжийн зардалд 1,669.8 мянган 100,681.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сангаас Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу тайлант онд 17010 иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ олгосон байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Т.Ганхүлэг санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийгмийн халамжийн бодлогын хүрээнд нийт 2 зорилго, 3 зорилт, 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 98.0 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 5,927,073.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 8,215.7 мянган төгрөгөөр буюу 58.1 хувиар буурсан байна.

Энэ нь тайлант онд ихэр хүүхэд, жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж, алдарт эхийн одон, насны хишиг, цалинтай ээж, өрх толгойлсон эцэг, эх хөтөлбөрийн зардлыг Э-халамж цахим системээр улсын төсвөөс шууд олгосонтой холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 9,898,848.6 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Ахмад настны тухай хуулийн дагуу “Зөвлөгөө өгөх үйлчилгээ”, “Явуулын үйлчилгээ”, “Өдрийн үйлчилгээ”-г ахмад настанд үзүүлэх, харьяалалгүй ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх бэлгийн багц нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах, хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх 4 хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах, 3 төрлийн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____